

Харилцаа холбоо, мэдээллийн
технологийн газрын даргын 2019 оны 06
дугаар сарын ... -ний өдрийн албан
бичгийн хавсралт

**“ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН АЛСЛАГДСАН СУМЫН БАГТ
ХӨДӨЛГӨӨНТ ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ХҮРГЭХ” ТӨСӨЛ**

**ТӨСЛИЙН ТЕХНИК БА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ
ШААРДЛАГА**

Нэг.Төслийн зорилго

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтээр 2019 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээний хүрээнд хөдөө орон нутгын алслагдсан сумын багт, хүн ам олноор суурьшсан цэгт хөдөлгөөнт холбооны сүлжээ шинээр байгуулан үйлчилгээг хүргэх зорилготой.

Хоёр. Төслийн хамрах хүрээ

Төслийн хүрээнд дараах нэр бүхий 5 цэгт хөдөлгөөнт холбооны үйлчилгээг нэвтрүүлнэ.
Үүнд:

№	Аймаг	Сум багийн нэрс	Сайт байгуулах газрын нэр, координат
1	Хөвсгөл	Цэцэрлэг /2-р баг/	Их амны даваа /49°42'48.47", 97°50'14.12"/
2	Увс	Тэс сум /4-р баг/	Хөх модны үзүүр /50°20'6.32", 93°30'0.1"/
3	Ховд	Чандмань /Талын булаг баг/	Тэмээтийн орой /47°22'41.9", 093°06'26.4"/
4	Сэлэнгэ	Цагаан нуур /Оргих баг/	Баянзүрх уул /49°55'37.35", 104°54'21.68"/
5	Ховд	Алтай сум /Алтангадас баг/	Банзан хүрэн /45°20'32.93", 92°18'29.44"/

Гурав. Бүх нийтийн үүрэгт үйлчилгээ үзүүлэгчид тавигдах техникийн тодорхойлолт болон шаардлага:

1. Үйлчилгээ үзүүлэгч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үүрэн холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч байх.
 - Тусгай зөвшөөрлийн хуулбар /Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгосон “Монгол Улсын нутаг дэвсгэрт хөдөлгөөнт холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эзэмшигч байх, гэрээний хуулбарын хамт./
 - Үйлчилгээ үзүүлэгч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт 3 дахь үеийн хөдөлгөөнт холбооны (2G болон түүнээс дээш) үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч байх.
 - Үйлчилгээ үзүүлэгч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт 3 дахь үеийн хөдөлгөөнт холбооны (2G болон түүнээс дээш) үйлчилгээ эрхлэх радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч байх.
2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
3. Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага /ОУЦХБ/-ын зөвлөмж, стандартыг баримтална.
4. ХХЗХ-ны 2010 оны 18 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Бүх нийтийн үүрэгт үйлчилгээний чанар, үндсэн үзүүлэлт, техникийн нөхцөлд тавигдах шаардлагыг хангана.
5. ХХЗХ-ны 2004 оны 08 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “ Харилцаа холбооны сүлжээ, инженерийн барилга байгууламжийг хэсэгчлэн түрээслэх журамыг мөрдлөг болгоно.
6. Тендерт оролцогч нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22-р зүйл /харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа нийт хуулийн этгээдээс эцсийн албан татвар ноогдуулах орлогын 2%-тай тэнцүү байна/-д заасны дагуу хуулийн хугацаанд тооцоо нийлж, хөрөнгө төвлөрүүлсэн байх, мөн Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд хөрөнгийн үлдэгдэлгүй болох тодорхойлолт авсан байх.
7. Сүлжээний ашиглалт, ажиллагааны байдлыг 24 цагаар хянах сүлжээ удирдлагын төвтэй, тогтвортой ажиллагааны түвшинг хангасан байх.
8. Сүлжээний тодорхойлолт - Тендерт оролцогч санал болгож буй БНҮ-г Үйлчилгээ үзүүлэгчийн төлөвлөсөн сүлжээний дэлгэрэнгүй тодорхойлолтыг гаргана.
9. Эхний нэг жилийн болон ирэх гурван жилийн үйлчилгээний хамрах хүрээ;
10. Сүлжээний ачааллын багтаамж;

11. Харилцан холболтын цэг. Тендерт оролцогч нь санал болгож буй үйл ажиллагааны эхний 5 жилд шаардагдах харилцан холболтын цэг, харилцан холболтын шугамын хэмжээ, тоог сайтар тооцоолсон байна. Ингэснээр бусад операторууд харилцан холболтоор хангах ажлыг зохион байгуулж төлөвлөх болно. Тендерт оролцогч нь өөрийн сүлжээг өргөтгөх бүрт дээрх мэдээллийг ХХМТГ-т өгч байна.

Дөрөв. Техникийн ерөнхий шаардлага.

а. Үндсэн сүлжээний хэсэг:

1. Сүлжээ нь хоорондоо харилцан уялдаа холбоотой 3 хэсгээс иж бүрдэл болно. Холбох сүлжээний хэсэг/access/, үндсэн сүлжээний дамжуулах байгууламжийн хэсэг/transmission/, холбох байгууламж /switching/-аас бүрдэнэ.
2. БНҮ-т үйлчилгээ үзүүлэгч нь дээрх гэрээгээр хүлээсэн үүргээ бүх бүрдэл хэсгээр хангасан байх шаардлагатай.

б. Сүлжээний тодорхойлолт:

Үйлчилгээ үзүүлэгч нь төлөвлөсөн сүлжээний дэлгэрэнгүй тодорхойлолтыг дараах байдлаар гаргана.

- Шаардлагатай дамжуулах байгууламж болон үйлчилгээний гүйцэтгэлийн үзүүлэлтүүд, холболтын байгууламж болон дамжуулах системийн технологийн тодорхойлолт;
- Хэрэв сансрын холбоогоор дамжуулан үйлчилгээ хүргэх бол Үйлчилгээний гэрээнд шаардагдах техникийн гүйцэтгэлийг харуулах төв хаб, төгсгөлийн төхөөрөмжийн үзүүлэлт, үүнд ашиглах давтамжийн зурвас, антенны техник өгөгдлүүд, хүлээн авагчийн мэдрэмж, шугамын төсөвлөсөн тооцоо, үйлчилгээний боломж, найдвартай ажиллагаа зэргийн нэгдсэн техникийн үзүүлэлт
- Эхний нэг жилийн болон ирэх гурван жилийн үйлчилгээний хамрах хүрээ;
- Холбогдох техникийн стандарт, давтамжийн нөхцөл/түүний дотор нийт зурвас, сувгийн тоо, ашиглалт/

с. Холбох сүлжээний хэсэг:

- БНҮ-т үйлчилгээ үзүүлэгч нь холбох сүлжээний хэсгийг нийтийн хэрэглээний дуут телефон болон хувийн хэрэглээний дуут телефон хэрэглэгчийг газрын болон сансрын дамжуулах байгууламжтай холбогдуулах шаардлагатай.

- Техникийн нөхцөл болон багтаамжийн хувьд *БНУ-т үйлчилгээний тодорхойлолт хэсэгт заасан* үйлчилгээг хангах техникийн нөхцөл бүхий холбох сүлжээний хэсэг нь БНУ -т үйлчилгээ үзүүлэх бүс нутагт байх шаардлагатай.
- Холбох сүлжээний хэсэг ойрын 5 жилд хэрэгцээний өсөлтийг хангах багтаамжийн чадвартай байна.

d. Дамжуулах байгууламжийн хэсэг:

1. Дамжуулах байгууламжийн хэсэг нь үндсэн сүлжээний хэсэг /backbone/ бөгөөд дараах хэсгүүдээс бүрдэж болно.
 - Газрын дамжуулах байгууламжийн хэсгүүд /шилэн кабель, тоон радио релей/
 - Сансрын сегментийн түрээс
 - Хиймэл дагуулын газрын станц эсхүл дамжуулах сүлжээний төгсгөлийн төхөөрөмжүүд
 - Алслагдсан терминал /сансрын хиймэл дагуулын сүлжээний/ түүнийг хянах HUB станц
2. Техникийн нөхцөл болон багтаамжийн хувьд *БНУ-т үйлчилгээний тодорхойлолт хэсэгт заасан* үйлчилгээг хангах техникийн нөхцөл бүхий холбох сүлжээний хэсэг БНУ-т үйлчилгээ үзүүлэх бүс нутагт байх шаардлагатай.
 - Холбох сүлжээний хэсэг ойрын 5 жилд хэрэгцээний өсөлтийг хангах багтаамжийн чадвартай байна.
 - Холбох сүлжээний хэсэг нь Олон улсын цахилгаан холбооны байгууллагын /ОУЦХБ/ зөвлөмж болон стандартуудыг хангахуйц байна.
3. Суурин болон хөдөлгөөнт холбооны сүлжээнүүдийн харилцан холболтын талаар дор дурдсан шаардлагуудыг хангана.
 - Орон нутагт байгуулсан үүрэн холбооны сүлжээ нь дээрх сүлжээнүүдтэй харилцан холболт хийх техникийн бүрэн боломжтой байх

Үйл ажиллагааны тодорхойлолт:

- БНУ-т үйлчилгээг эрхлэх ашиглалт, үйлчилгээ, менежментийн ерөнхий тодорхойлолт түүний дотор шинээр ажилтан ажиллагсад авах, баг, орон нутгийн холбооны төгсгөлийн төхөөрөмжийг ажиллуулахад шаардлагатай удирдлага, зохион байгуулалт
- Ашиглалт, үйлчилгээ явуулахад шаардлагатай газар буюу зурвас газар, түүний ашиглалтын зардлын товч тодорхойлолт;
- Чанарын стандарт, багтаамж. хяналт, ярианы чанарыг хэмжих, үнэлэх үнэлэмж, үйлчилгээний журам, системийн тодорхойлолт;

Тав. Бүх нийтийн үүрэгт үйлчилгээний тодорхойлолт

- Үйлчилгээ эрхлэгч нь гэрээний хугацаанд заавал үйлчилгээ эрхлэх бүс нутагт заавал үзүүлэх БНҮ-т Үйлчилгээг явуулна.
- Заавал үзүүлэх БНҮ-т Үйлчилгээг дараах хэлбэрээр тодорхойлно. Үүнд:

1. Нийтийн хэрэглээний дуут телефон – Заавал үйлчилгээ эрхлэх бүс нутагт ОУЦХБ-ын дуут телефон үйлчилгээний чанарын зөвлөмж болон стандартыг мөрдлөг болгон дараах нөхцлийн дагуу нийтийн хэрэглээний нэгээс доошгүй телефоныг ажиллуулна.

- a. “Нийтийн хэрэглээний телефон”-д нийтэд хүртээмжтэй байх телефон цэг эсхүл төлбөртэй телефон орно.
- b. Нийтийн хэрэглээний телефон холбоо нь цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээнд холбогдох боломжтой байх шаардлагатай.
- c. Нийтийн хэрэглээний телефон холбоо нь цахилгаан холбооны сүлжээтэй харилцан холбогдож, орон нутаг дотор, хот хооронд болон олон улсын орох, гарах ярианы дуудлагын үйлчилгээг үзүүлэх боломжтой байх шаардлагатай.

Нийтийн хэрэглээний дуут телефоны үйлчилгээний төгсгөлийн төхөөрөмжийн байрлал:

- a) Үйлчилгээ үзүүлэгч нь нь тоног төхөөрөмж суурилуулах тухайн орон нутгийн үйлчилгээ эрхлэгчийн байрлалыг тухайн тохиолдол бүрээр сонгох ба энэ нь багийн төв эсхүл төрийн бус байгууллагын суурин, барилгын газар, уурхай гэх мэт тухайн суурин газарт аль тохиромжтой гэж үзсэн газар байна.
- b) Үйлчилгээ үзүүлэгч нь нийтийн хэрэглээний телефоны төгсгөлийн төхөөрөмжийг байрлуулахад тохиромжтой газар, түүнийг ажиллуулах хариуцлагатай хүн/өрхийг сонгохдоо тухайн орон нутгийн ЗДТГ болон хариуцлагатай хүмүүстэй зөвлөлдсөн байна.
- c) Үйлчилгээ үзүүлэгч нь сүлжээ ашиглалтад оруулж үйлчилгээг эхлэх шатанд дээр дурдсан сонголтын явцыг баримтжуулах ба энэ нь төлбөрийг гүйцэтгэх нэг нөхцөл болно.
- d) БНҮ-ний шаардлагыг хангах ашиглалт, үйлчилгээний байрлалыг Үйлчилгээ үзүүлэгч сонгох эрхтэй бөгөөд хариуцан ажиллуулах хүнийг сонгохдоо дараах шалгуурыг анхаарвал зохино. Үүнд:
 - (i) Бүс нутаг дахь айлуудын байрлах газар зүйн төвлөрөл
 - (ii) Техникийн ур чадвар – тухайлбал механик эсхүл цахилгаан холбооны мэдлэгтэй, телевизийн хүлээн авагч антенна, нарны эрчим хүчний зайг ашигладаг туршлагатай байх;
 - (iii) Тухайн орон нутагтаа нэр хүндтэй хариуцлагатай хувь хүн эсхүл өрх айл байх;
 - (iv) Орчин үеийн техник, үйлчилгээг мэдэрсэн байх;
 - (v) Санхүүгийн талаар найдвартай, хариуцлагатай байх;

- 2. Хувийн дуут телефон холбоо-ны үйлчилгээнд орон нутаг, хот хооронд болон олон улсын орох, гарах ярианы үйлчилгээ орох ба доор дурьдсан нөхцөл шаардлагын дагуу заавал үйлчилгээ үзүүлэх бүс нутагт явуулна.**
- а. Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээ үзүүлэх бүс нутагт өөрийн техникийн шийдлийн дагуу дамжуулах болон холбох төхөөрөмжийг сонгон үйлчилгээг эхэлсэн байна.
 - i. Үйлчилгээ үзүүлэгч нь хувийн дуут телефон холбооны үйлчилгээний найдвартай ажиллагааны талаар иргэдэд танилцуулан эрэлт хэрэгцээг судлан тогтоож, үйлчилгээний төлөвлөгөө, үнэ тарифыг энэхүү гэрээг үйлчилж эхэлсэн өдрөөс хойш нэг жилийн дотор олон нийтэд мэдэгдсэн байна.
 - б. Үйлчилгээ үзүүлэгч нь хувийн дуут телефон холбооны үйлчилгээг хүссэн өргөдлийг хүлээн авснаас хойшхи 1-ээс доошгүй сарын хугацаанд биелүүлэх шаардлагатай.

3. Оператор болон Яаралтай дуудлагын үйлчилгээ- Үйлчилгээ үзүүлэгч нь заавал үйлчилгээ үзүүлэх бүсэд нийтийн хэрэглээний болон хувийн дуут телефоны үйлчилгээний хүрээнд яаралтай дуудлагын үйлчилгээг шууд буюу операторын тусламжтай үзүүлнэ.

4. Үйлчилгээний тариф

- а) Талууд өөрөөр тохиролцоогүй болон хууль эсхүл журманд өөрөөр заагаагүй бол Үйлчилгээ үзүүлэгч нь тусгай зөвшөөрөл болон доор дурьдсан нөхцөл, шаардлагыг мөрдлөг болгон БНҮ-ний үнийг тогтооно. Үүнд:
 - i. Үнэ тарифын дэлгэрэнгүй тайлбарыг нийтийн хэрэглээний телефон ажиллуулж буй цэгт мэдээлсэн байна. Бүх хэрэглэгчийн төлбөр нь баталсан тарифаар мөрдөгдөх шаардлагатай.

5. Найдвартай ажиллагаа

Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү гэрээний хугацаанд заавал үйлчилгээ хүргэх бүсэд БНҮ-г тасралтгүй үзүүлэх нөхцөлийг хангана.

Зургаа. Бүх нийтийн үүрэг хүлээх хугацаа

- а. Үйлчилгээний найдвартай ажиллагаа, чанарын үзүүлэлтийн дагуу заавал үйлчилгээ үзүүлэх цэгүүдэд бүх нийтийн үүрэгт үйлчилгээг 60 сарын хугацаанд тогтмол, тасралтгүй хүргэнэ.

Долоо. Үйлчилгээний чанар, найдвартай ажиллагаа, тайлан, хяналт, шалгалт

1. Үйлчилгээний чанар

- a) БНУ- ний чанарын шалгуур - Үйлчилгээ үзүүлэгч нь ХХЗХ-ноос баталсан Бүх нийтийн үүрэгт үйлчилгээний чанар, үндсэн үзүүлэлт, техникийн нөхцөлд тавигдах шаардлагыгхангах үүрэг хүлээнэ. Эдгээр чанарын шалгуур нь тухайн үйлчилгээг үзүүлэхэд ашиглах технологийн шаардлагад нийцсэн байна.
- b) **Заавал үзүүлэх үйлчилгээний чанарын тайлан** – БНУ-ний улирлын чанарын тайланг улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор гаргаж, БНҮҮС-д ирүүлнэ. Тайланд бүх нийтийн үүрэгт үйлчилгээ хүргэсэн тухай дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлнэ. / Гэмтэл саатал, гологдлын мэдээ, засварласан хугацаа, гомдол санал, шийдвэрлэлтийн байдал, Сүлжээ зохион байгуулалт гэх мэт/
- c) Захиалагчаас томилогдсон техникийн аудит, хяналтын баг төсөл хэрэгжих явцад 2-оос доошгүй удаа хяналт шалгалт хийнэ. Хяналтын зардлыг гүйцэтгэгч тал гэрээний үнийн дүнгийн 2 хувиар бодож бүрэн хариуцна. Энэ тухай албан бичгээр баталгаажуулж захиалагчид ирүүлнэ.

**ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН АЛСЛАГДСАН СУМЫН БАГТ ХӨДӨЛГӨӨНТ
ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ХҮРГЭХ ГАЗРЫН НЭРС, ТӨСӨВТ ӨРТӨГ**

№	Аймаг	Сум багийн нэрс	Төсөвт өртөг
1	Хөвсгөл	Цэцэрлэг /2-р баг/	430,000,000
2	Увс	Тэс сум /4-р баг/	
3	Ховд	Чандмань /Талын булаг баг/	
4	Сэлэнгэ	Цагаан нуур /Оргих баг/	
5	Ховд	Алтай сум /Алтангадас баг/	